



САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰ
ᠰᠠᠨᠬᠡᠭᠢᠢᠨ
ᠵᠣᠬᠢᠴᠢᠭᠤᠯᠠᠬᠤ
ᠬᠣᠷᠤᠭ᠎ᠠ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН 2020 ОН

АГУУЛГА

НЭГ.	МЭНДЧИЛГЭЭ	4
ХОЁР.	ОН ЦАГИЙН ТОВЧООН	6
ГУРАВ.	ХУРААНГУЙ	8
ДӨРӨВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА	9
ТАВ.	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН	10
ЗУРГАА.	ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	11
ДОЛОО.	ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	12
НАЙМ.	САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	13
ЕС.	БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	14
АРВ.	"КОВИД-19"-ИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО	24
АРВАН НЭГ.	БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	28
АРВАН ХОЁР.	ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА	31
АРВАН ГУРАВ.	ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	35
АРВАН ДӨРӨВ.	МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	36
АРВАН ТАВ.	ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА	38
АРВАН ЗУРГАА.	СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ	40
АРВАН ДОЛОО.	КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС	41
АРВАН НАЙМ.	МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ	42
АРВАН ЕС.	ТӨСӨВ, САНХҮҮ	43
ХОРЬ.	ОЛОЛТ, АМЖИЛТ	44

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1.** СЗХ–ны бүтэц, зохион байгуулалт
- Зураг 2.** СЗХ–ны албан хаагчдын мэдээлэл
- Зураг 3.** Зохицуулалтын салбарын онцлох үзүүлэлтүүд
- Зураг 4.** Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд
- Зураг 5.** Үнэт цаасны зах зээлийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл
- Зураг 6.** ББСБ–ын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл
- Зураг 7.** Зайны хяналт, шалгалтын мэдээлэл
- Зураг 8.** Газар дээрх хяналт, шалгалтын мэдээлэл, салбарын оролцогчдоор
- Зураг 9.** Албан шаардлага, салбараар
- Зураг 10.** Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээ
- Зураг 11.** Гадаадын хамтран ажиллагч байгууллагууд
- Зураг 12.** Төсвийн гүйцэтгэл
- Зураг 13.** Нийт зардал /хувиар/

- Хүснэгт 1.** Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт
- Хүснэгт 2.** 2020 онд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актууд
- Хүснэгт 3.** ББСБ–уудын бүртгэл, зөвшөөрлийн мэдээлэл
- Хүснэгт 4.** Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн тоо
- Хүснэгт 5.** Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн тоо

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	Засгийн газар
ЭЖДХ	Зээлийн жигнэсэн дундаж хүү
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
МБХ	Монголын банкны холбоо
МДЗХ	Монголын даатгалын зуучлагчдын холбоо
МДХ	Монголын даатгалын холбоо
МИК	Монголын ипотекийн корпораци
ММНБИ	Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
ММУИ	Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт
МУТС	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
МУЦСК	Монголын үнэт цаасны санхүүжилтийн корпораци
МХХ	Монголын хуульчдын холбоо
НОСК	Нийслэлийн орон сууцны корпораци
СБСА	Санхүүгийн боловсрол, сургалтын алба
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТББ	Төрийн бус байгууллага
ТГБ	Төлбөр гүйцэтгэгч банк
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УБАШ	Улсын байцаагчийн албан шаардлага
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын Их Хурал
ҮМҮЧАЭҮХ	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоо
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮХХЗҮЭАЭ	Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн арилжаа эрхлэгч
ХАА	Хөдөө аж ахуй
ХААГБТЭБНМБНХ	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЖДХ	Хадгаламжийн жигнэсэн дундаж хүү
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ФАТФ	Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага
МАРИХ	Монголын хөдөө аж ахуйн барааны үнийн индекс

■ МЭНДЧИЛГЭЭ



Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны үйл ажиллагааны тайланг Танд өргөн барьж байна.

Хэдийгээр дэлхий нийтэд тархаад буй коронавирусын цар тахлаас үүдэж нийгэм, эдийн засаг гээд бүхий л салбарт хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн ч улс орон бүр боломж, бололцоогоо дайчлан хамтын хүчээр даван туулсан жил боллоо. Монгол Улс ФАТФ-ын “Саарал жагсаалт”-аас богино хугацаанд гарахад СЗХ болон зохицуулалтын байгууллага хоорондын нягт хамтын ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэсэн. Мөн Европын холбооны комиссоос мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй улс орнуудын “Хар жагсаалт”-аас хасав.

СЗХ чиг үүргийнхээ хүрээнд зохицуулалттай мэргэжлийн үйлчилгээ эрхлэгч 5,600 гаруй аж

ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавин ажилладаг. Бидний хувьд шинэ технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, санхүүгийн зах зээл дээрх хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорилгоо болгож олон ажлыг хийж хэрэгжүүллээ.

Тухайлбал, Хөрөнгийн зах зээлд төлбөр тооцооны T+2 системийг нэвтрүүлж, биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны зохицуулалтыг бий болгон, санхүүжилт босгох таатай нөхцөлийг бүрдүүлж, үнэт цаасны давхар бүртгэлийн систем буюу хоёр биржийн хооронд үнэт цаасыг чөлөөтэй хөрвүүлж, арилжаалах орчинг бүрдүүлсэн. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хүрээнд санхүүгийн бус бизнесийн томоохон салбарууд болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн арилжааны үйл ажиллагааг бүрэн зохицуулалтад оруулж бүртгэлжүүллээ. Засгийн газраас хэрэгжүүлж буй “Түрээсийн орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэж санхүүгийн хэрэгсэл болгосон бол даатгалын салбарт олон улсын стандартад нийцүүлж даатгалын зохицуулалтын орчинг өөрчилсний зэрэгцээ даатгалын компаниудаас нийгмийн хариуцлагын хүрээнд коронавирусын цар тахлын эрсдэлээс сэргийлсэн хэд хэдэн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлээд байна. Мөн Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн баталснаар хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон үр дүн өгсний зэрэгцээ санхүүгийн салбарын эрүүл тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй бодлогын томоохон шийдвэр боллоо.

Бид 2021 онд эдийн засгийн тэгш хүртээмжид хувь нэмэр оруулан санхүүгийн хүртээмжийг

■ МЭНДЧИЛГЭЭ

нэмэгдүүлж ажиллахын зэрэгцээ үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгон, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүжилтийн таатай нөхцөлийг бүрдүүлж, технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжинэ.

Зохицуулалттай салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хөрөнгийн болон даатгалын зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, тэдгээрийн зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

Түүнчлэн санхүүгийн зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагч, даатгуулагчдын итгэлийг хүлээсэн санхүүгийн үйлчилгээг хялбар, шуурхай хүргэхэд хамтран ажилладаг Төрийн бодлого тодорхойлогчид, Мэргэжлийн холбоод болон зохицуулалтын байгууллагууд Та бидний хамтын ажиллагаа улам өргөжин тэлж амжилт, үр бүтээлээр дүүрэн байна гэдэгт итгэлтэй байна.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

ОН ЦАГИЙН ТОВЧООН



Нэгдүгээр сар

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох ҮХХЗҮЭАЭ-дийг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг СЗХ хэрэгжүүлэхээр хуульчлагдав.

Хоёрдугаар сар

Ковид-19 цар тахлын нөлөөллийг бууруулахаар ББСБ, ХЗХ-дын зээлдэгчдийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах шийдвэрийг гаргав.

Зах зээлийн судалгаа, хөгжлийн газар, Үл хөдлөх хөрөнгө зуучлал үнэт эдлэлийн зохицуулалтын газар, Санхүүгийн боловсрол, сургалтын алба, Компанийн засаглал, комплайнсын хэлтэс байгуулагдав.

Гуравдугаар сар

Үнэт цаасны дараа төлбөр тооцооны T+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэв.

Дөрөвдүгээр сар

Цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах болон “Зөвшөөрлийн цахим систем”-ийг нэвтрүүлэв.

Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлагчдад тусгай зөвшөөрөл олгож эхлэв.



Тавдугаар сар

Олон улсын санхүүжилтийн корпоративтай ногоон санхүүжилт, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдэд “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг үзэглэв.

Үнэт металл, үнэт эдлэл, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдэд тусгай зөвшөөрөл олгож эхлэв.



Наймдугаар сар

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэх нээлттэй өдөрлөг зохион байгуулав.



Долоодугаар сар

ФАТФ манай улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гарахтай холбоотой өгсөн үүрэг даалгавруудыг амжилттай биелүүлснийг мэдэгдэв.



Зургаадугаар сар

Гадаад валютын арилжаа эрхэлж буй ББСБ төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд холбогдож, харилцагчдад И-баримт олгох, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хөнгөвчлөх нөхцөл бүрдэв.



“Хувьцаат компанийн комплайнс, мэдээллийн ил тод байдал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулав.



Есдүгээр сар

ХААГБТЭБНМБНХ, ММНБИ, ММҮИ, МХХ, МБХ, ММНБИ, ММҮИ, МДХ, МДЗХ-той хамтран ажиллах гэрээ байгуулав.



Арваннэгдүгээр сар

“Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр” зарлагдав.

Цахим гарын үсэг бүхий албан бичгийг иргэд, аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч, илгээж эхлэв.

МУТСТ чиглэлээр Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн үндэсний холбоотой сургалтын чиглэлд хамтран ажиллах гэрээ байгуулав.

Арванхоёрдугаар сар

Биржийн бус зах зээлийн арилжааны хууль эрх зүйн орчин бүрдэв.

Аравдугаар сар

ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар Монгол Улсыг стратегийн дутагдалтай орнуудын жагсаалт буюу “Саарал жагсаалт”-аас гарсныг зарлав.

Анхны хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгов.

ХУРААНГУЙ

Коронавирусийн цар тахлын улмаас ихэнх улс орнууд 2020 оны эхний хагас жилийг хөл хорионы байдалтай өнгөрүүлэх хатуу арга хэмжээг авсны улмаас дэлхийн хэмжээнд эдийн засгийн үйл ажиллагаа эрс багасаж дэлхийн эдийн засаг 2020 онд таамагласнаас 1.9 хувиар буурч –4.9 хувьд хүрэв. Монгол Улсын ДНБ 2020 онд 37.0 их наяд төгрөгт хүрч, 5.3 хувиар буурав. Гадаад худалдааны хувьд экспорт 7.6 сая ам.доллар, импорт 5.3 сая ам.долларт хүрч нийт тэнцэл 2.3 сая ам.доллар гарч өмнөх оноос 53.0 хувиар сайжирлаа. Тэргүүлэх салбарууд болох хөдөө аж ахуйн салбар 10.7 хувиар, эрчим хүчний салбар 6.7 хувиар, мэдээлэл холбооны салбар 4.0 хувиар, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа 1.9 хувиар тус тус өссөн бол уул уурхайн салбар 7.5 хувиар, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 19.7 хувиар буурсан. Бусад салбарууд болох боловсруулах үйлдвэр 12.5 хувиар, усан хангамж 17.6 хувиар, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа 20.3 хувийн огцом өсөлтийг үзүүлсэн бол бөөний болон жижиглэн худалдаа 6.9 хувиар, зочид буудал ба байр орон сууц 26.9 хувиар агшсан үзүүлэлттэй байна.

Үнэт цаасны зах зээлд 2020 онд 591 хуулийн этгээд СЗХ–ны зохицуулалттайгаар үйл ажиллагаа эрхэлж, данс эзэмшигчдийн тоо 2.4 саяд хүрлээ. Нийт үнэт цаасны арилжаа өнгөрсөн оноос 54.5 хувиар буурч, 65.4 тэрбум төгрөгт хүрэв. Харин зах зээлийн үнэлгээ 3.0 их наяд төгрөгт хүрч 12.5 хувиар өссөн бол ТОП–20 индекс 336.1 нэгжээр буурч 19,285.8–д хүрсэн байна.

ХАА–н гаралтай бараа, түүхий эдийн 488.7 тэрбум төгрөгийн арилжаа тайлант онд явагдсан нь өмнөх оноос 216.3 тэрбум төгрөгөөр буурчээ. ХААБ–ийн МАРИХ индекс 918,691.4 нэгжид хүрч өмнөх оноос 124,375.3 нэгж буюу 15.7 хувиар өссөн.

Даатгалын салбарт нийт 319 даатгалын компани, зуучлагч, хохирол үнэлэгч, аудитын компани, актуарч, аудитор, 2,473 даатгалын төлөөлөгч санхүүгийн зах зээлд бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэн ажиллав. Даатгалын салбарын нийт хөрөнгө 382.1 тэрбум төгрөгт хүрснээс 45.4 хувь буюу 173.5 тэрбум төгрөгийг нөөц сан эзэлж байна. Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2020 онд нийт 201.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлжээ. Нийт 66.8 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжид зарцуулсны 3.6 тэрбум төгрөг буюу 5.3 хувийг дотоодын давхар даатгагчид төлсөн байна. Даатгалын компаниудын нийт нөхөн төлбөрийн зардал 2020 онд 59.8 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.6 хувиар буурчээ.

ББСБ–ын салбарт тайлант онд 532 ББСБ үйл ажиллагаа явуулж, салбарын харилцагч, зээлдэгчдийн тоо 1.9 дахин нэмэгдэж тус бүр 2.8 сая болон 788.1 мянгад хүрсэн нь санхүүгийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ уг салбарт хурдацтай нэвтэрсэнтэй холбоотой огцом өсөлтийг үзүүлжээ. Нийт хөрөнгө 2.0 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 16.0 хувиар өсөв. Үүний 1.3 их наяд төгрөгийг зээлийн өрийн үлдэгдэл эзэлж байгаа бөгөөд 84.8 хувь нь хэвийн зээл байна.

ХЗХ–дын тоо өмнөх оноос 4.6 хувиар буурч 249 болж, гишүүдийн тоо 2.4 хувиар өсөж 72,651–т хүрлээ. Тайлант онд ХЗХ–дын нийт хөрөнгө өмнөх оноос 15.0 хувиар өсөж 256.0 тэрбум төгрөгт хүрчээ.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын 167 компани 2020 онд тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн ба нийт 610.3 мянган м.кв талбай, 281.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг зуучлуулан худалдаж, худалдан авч, шилжүүлсэн бол нийт 88.6 мянган м.кв талбай, 39.9 тэрбум төгрөгийн үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийг хөлслүүлж, түрээслүүлжээ.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааны 30 хуулийн этгээд, 399 иргэн тусгай зөвшөөрөлтэйгөөр 2020 онд үйл ажиллагаа явуулж, үнэт металл, үнэт эдлэлийн 577.0 тэрбум төгрөгийн худалдах, 624.2 тэрбум төгрөгийн худалдан авах арилжаа хийгдлээ.

📍 Засгийн газрын IV байр, Бага тойруу–3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160

☎ 976 51 264444

✉ press@frc.mn

🌐 www.frc.mn

📌 Санхүүгийн зохицуулах хороо

📍 @FRC_of_Mongolia



■ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА

СЗХ нь 2005 онд УИХ-аас Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг баталснаар 1994 онд байгуулагдсан Үнэт цаасны хорооны суурин дээр даатгал, бичил санхүүгийн салбарын зохицуулалт нэмэгдэн банкнаас бусад санхүүгийн зах зээлийг зохицуулахаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн түүхтэй.

СЗХ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгч,

даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, банкнаас бусад санхүүгийн зах зээлд хяналт шалгалт хийх, бодлого, зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиг үүрэгтэй.

2020 онд СЗХ нь нийт 142 албан хаагчтайгаар 6 салбарын 3,260 зохицуулалттай этгээд, 2,473 даатгалын төлөөлөгчдөд хяналт, шалгалт хийж, бодлогын арга хэмжээ авч ажиллалаа.


АЛСЫН ХАРАА

Чөлөөт, шударга өрсөлдөөнт, хэрэглэгчдийн эрх хамгаалагдсан, хүртээмжтэй, олон тулгуурт, тогтвортой санхүүгийн зах зээлийг цогцлоож, эдийн засгийн өсөлт, хөгжлийг тэтгэнэ.

ЭРХЭМ ЗОРИЛГО


Санхүүгийн зохистой бодлого, үр ашигтай хяналт шалгалт, оновчтой зохицуулалтыг хэрэгжүүлж, олон тулгуурт, хэрэглэгчдийн эрхийг хамгаалсан, итгэлийг нэмэгдүүлсэн тогтвортой санхүүгийн зах зээлийг хөгжүүлнэ.

ҮНЭТ ЗҮЙЛС




■ САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

Зураг 1. СЗХ-ны бүтэц, зохион байгуулалт



2020 онд хөдөө, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй зохицуулалтын байгууллагуудын нэгдсэн бүртгэл хөтөлж, шаардлагатай мэдээллүүдийг тогтоосон хугацаанд СЗХ-нд ирүүлэх, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, СЗХ-ноос өгсөн чиглэлийн дагуу зохицуулалтын байгууллагуудад хяналт шалгалт хийх үүрэг бүхий орон тооны бус орон нутгийн 63 төлөөлөгч 21 аймагт ажилласан.

Зураг 2. СЗХ-ны албан хаагчдын мэдээлэл



ОНЦЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зураг 3. Зохицуулалтын салбарын онцлох үзүүлэлтүүд



ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн банкнаас Монгол улсад 27 сая ам.долларын тусламж төсөвлөсөн.

Үүнд: эмч, сувилагч, эмнэлгийн ажилтнуудад зориулсан сургалт, эмнэлэг болон лабораторийн тоног төхөөрөмж, материал зэрэг юм.

- Олон улсын валютын сангийн тооцоолсноор дэлхийн эдийн засаг 2020 оны таамагласнаас 1.9 хувиар буурч –4.9 хувьд хүрэв.
- Коронавирусийн цар тахлын улмаас дэлхийн хэмжээнд эдийн засгийн өсөлт эрс буурсан.

Бичил санхүүгийн салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байсан ч 2020 онд цар тахлын улмаас олон бичил бизнесүүд түр болон удаан хугацаагаар үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон.



Хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд 2020 онд өмнөх оноос дараах байдлаар өөрчлөгдсөн байна.

- MSCI индекс 13.5 хувиар
- Германы DAX 5.7 хувиар
- Японы Nikkie 32.1 хувиар
- Хятадын CSI 300 27.2 хувиар тус тус өссөн бол
- Францын CAC 7.1 хувиар буурсан.

Дэлхийн улс орнуудын гадаадын шууд хөрөнгө оруулалт цар тахлын улмаас 42 хувиар буурсан.

Энэ нь 2009 оны дэлхийн санхүүгийн хямралын дараах үзүүлэлтээс 30 гаруй хувиар бага юм.

Европын холбооны 17 улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт 66.7 хувиар буурсан.

Өмнөд Азийн улсууд болох Энэтхэг, Бангладеш, Вьетнам зэрэг улсууд бичил санхүүгийн салбарын үйлчилгээгээр тэргүүлсээр байна.

■ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Зураг 4. Санхүүгийн салбарын статистик үзүүлэлтүүд



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

- » ТОП-20 ИНДЕКС: 19285.8 нэгж
- » MSE A: 9122 нэгж
- » ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТОО: 315
- » ҮНЭТ ЦААСНЫ КОМПАНИЙН ТОО: 53
- » ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн арилжааны дүн: 488.7 тэрбум төгрөг
- » МИК: 83,674 зээлдэгчийн 4.4 их наяд төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас

ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

- » НИЙТ ХӨРӨНГӨ: 382.1 тэрбум төгрөг
- » НИЙТ ХУРААМЖ: 201.5 тэрбум төгрөг
- » ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ХУРААМЖ: 36.4 тэрбум төгрөг
- » НӨӨЦ САН: 173.5 тэрбум төгрөг
- » ГҮНЗГИЙРЭЛТ: 0.57 хувь
- » НЯГТРАЛ: 61,117 төгрөг


БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР

- » ББСБ-ЫН ТОО: 532
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 2.0 их наяд төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 1.3 их наяд төгрөг
- » ЗЖДХ: 2.8 хувь
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 788.1 мянга
- » ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН НИЙТ ЗЭЭЛД ЭЗЛЭХ ХУВЬ: 10.3 хувь

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ САЛБАР

- » ХЗХ-НЫ ТОО: 249
- » НИЙТ ХӨРӨНГӨ: 256.0 тэрбум төгрөг
- » НИЙТ ЗЭЭЛ: 167.6 тэрбум төгрөг
- » НИЙТ ХАДГАЛАМЖ: 182.2 тэрбум төгрөг
- » ЗЖДХ: 3.0 хувь, ХЖДХ: 1.5 хувь
- » ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 35.9 мянга
- » ЗЭЭЛДЭГЧДИЙН ТОО: 35.8 мянга

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



2020 онд СЗХ-ны 24 удаагийн хуралдаанаар 1086 асуудлыг хэлэлцэн 1051 тогтоол, СЗХ-ны даргын 396 тушаал, Ажлын албаны даргын 374 тушаал тус тус гарган бүрэн эрхээ хэрэгжүүлж ажиллалаа.

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 1. Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт

№	Дээд газрын тогтоол, шийдвэрийн биелэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Гүйцэтгэл
1	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	5	81%
2	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл	7	90%
3	Монгол Улсын Засгийн газрын 2016–2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр	6	84.4%
4	Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	59	96.7%
5	Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх төлөвлөгөө	28	96.7%
6	“Зээлийн хүүг бууруулах стратеги–2018–2023”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	31	88%
7	Чанаргүй активыг бууруулах стратегийн баримт бичиг	8	81%
8	Мөнгөний болон хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төлөвлөгөө	18	80.4%
	НИЙТ	162	87.4%

Санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой 23 хууль, 117 дүрэм, журам, зааврын хэрэгжилтийг хангуулж ажилласан. Нийт дүрэм, журам, зааврын 49 нь үнэт цаасны зах зээлд, 27 нь даатгалын зах зээлд, 17 нь ББСБ–ын салбарт, 7 нь ХЗХ–ны салбарт, 5 нь ҮХХЗҮЭАЭ–ийн салбарт, бусад 12 дүрэм, журам, зааврыг зохицуулалтын хүрээндээ хэрэгжүүллээ.

СЗХ нь 2020 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 бүлгийн хүрээнд 160 ажил, үйлчилгээ хийж гүйцэтгэхээр төлөвлөн 91 хувьтай биелүүлж ажиллав. Түүнчлэн санхүүгийн зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой УИХ–ын 2, ЗГ–ын 2, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 4 бодлогын баримт бичгийн 162 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг 87.4 хувьтай гүйцэтгэлээ.

Мөн УИХ–ын 2020 оны 8 дугаар сарын 28–ны өдрийн 21 дүгээр тогтоолоор баталсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”–д хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын шимтгэл, хураамжийг бууруулах чиглэл бүхий ажил тусгагдсан.

Энэхүү арга хэмжээтэй холбоотойгоор СЗХ–ны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар холбогдох төр, хувийн хэвшил, дэд бүтцийн байгууллагууд, мэргэжлийн холбоодын төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулагдаж, 8 чиглэлээр дэд ажлын хэсгүүдэд хуваагдан ажиллаж байна. Ажлын хэсгүүдээс холбогдох журмууд боловсруулах, стратегид тусгагдсан ажлуудтай холбоотойгоор шаардлагатай хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал, дүгнэлт боловсруулах ажлуудыг шуурхай зохион байгуулан хэрэгжүүлж байна.

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх хүрээнд

СЗХ–ноос 2020 онд баталсан нийт 11 захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн тухай бүр захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажилласан. Мөн СЗХ–ноос баталж захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдсэн 6 хэм хэмжээний актад 7 удаа өөрчлөлт оруулсныг тухай бүр хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хянуулж, холбогдох хөдөлгөөн хийгдсэн.

Хүснэгт 2. 2020 онд бүртгэгдсэн захиргааны хэм хэмжээний актууд

№	Тогтоол, тушаалын нэр, дугаар	ХЗДХЯ–нд бүртгэгдсэн огноо	Захиргааны хэм хэмжээний актын нэр
1	СЗХ–ны 2019.12.27–ны өдрийн 441 дүгээр тогтоол	2020.01.10–ны өдрийн 4622 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээ, үе шаттай нэмэгдүүлэх хуваарийг шинэчлэн тогтоох тухай журам
2	СЗХ–ны дарга, Сангийн сайдын 2020.01.14–ний өдрийн 10/6 тоот хамтарсан тушаал	2020.01.27–ны өдрийн 4674 дугаарт бүртгэсэн	Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам
3	СЗХ–ны дарга, Сангийн сайдын 2020.01.14–ний өдрийн 11/5 тоот хамтарсан тушаал	2020.01.27–ны өдрийн 4673 дугаарт бүртгэсэн	Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам
4	СЗХ–ны 2020.01.15–ны өдрийн 10 дугаар тогтоол	2020.01.27–ны өдрийн 4672 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх, хорогдуулах, шинээр хувьцаа гаргах, худалдах, шилжүүлэхэд мөрдөх журам
5	СЗХ–ны 2020.03.11–ний өдрийн 114 дүгээр тогтоол	2020.03.23–ны өдрийн 4737 дугаарт бүртгэсэн	Даатгалын зах зээлийн ёс зүйн журам
6	СЗХ–ны 2020.03.11–ний өдрийн 120 дугаар тогтоол	2020.03.23–ны өдрийн 4738 дугаарт бүртгэсэн	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам
7	СЗХ–ны 2020.04.08–ны өдрийн 179 дүгээр тогтоол	2020.04.21–ний өдрийн 4265 дугаарт бүртгэсэн	Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам
8	СЗХ–ны 2020.04.08–ны өдрийн 181 дүгээр тогтоолоор	2020.04.21–ний өдрийн 4766 дугаарт бүртгэсэн	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам
9	СЗХ–ны 2020.06.29–ний өдрийн 495 дугаар тогтоол	2020.07.22–ны өдрийн 4835 дугаарт бүртгэсэн	Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам
10	СЗХ–ны 2020.08.12–ны өдрийн 757 дугаар тогтоол	2020.08.26–ны өдрийн 4854 дугаарт бүртгэсэн	Монгол Улсын хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих журам
11	СЗХ–ны 2020.09.09–ний өдрийн 880 дугаар тогтоол	2020.09.15–ны өдрийн 4867 дугаарт бүртгэсэн	Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2. Санхүүгийн үйлчилгээг зохицуулах хүрээнд

2020 онд санхүүгийн үйлчилгээг зохицуулах чиг үүргийн хүрээнд салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар дараах арга хэмжээг авч ажиллалаа:

Үнэт цаасны зах зээл: СЗХ–ны 2020 оны 29 дүгээр тогтоолоор үнэт цаасны дараа төлбөр тооцооны T+2, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчмыг нэвтрүүлэхээр шийдвэрлэж, дэд бүтцийн байгууллагууд болон зах зээлийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд СЗХ–ны удирдлага дор бэлтгэл ажлыг ханган 2020 оны 3 дугаар сарын 31–ний өдөр системийн хэмжээнд энэхүү горимд шилжсэн.


Ингэснээр хөрөнгө оруулагчид өөрийн эрсдэлийг үнэлүүлсний үндсэн дээр 100 хувийн эх үүсвэрээ байршуулахгүйгээр өөрийн эрсдэлд уялдсан байдлаар



захиалгын дүнгийн 30 хувь хүртэл бууруулсан хэмжээгээр эх үүсвэр байршуулан захиалга өгч арилжаанд оролцох, захиалга биелсэн нөхцөлд үлдэгдэл төлбөрийг шилжүүлэх боломж бий болохын зэрэгцээ, дэд бүтцийн байгууллагууд брокер, дилерийн компаниудаас авдаг шимтгэл хураамж буурах, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болсон.

СЗХ–ны 2020 оны 28 дугаар тогтоолоор хувьцаат компаниудын ногдол ашгийг түргэн шуурхай, хувьцаа эзэмшигчдэд чирэгдэл багатайгаар хуваарилах үүднээс ногдол ашиг тараах ажиллагааг “ҮЦТХТ” ХХК–аар дамжуулан тараахаар шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн хүрээнд хувьцаат компаниуд жил бүр өөрийн байран дээр ногдол ашгийг тараах явдал зогсож, хувьцаа эзэмшигч нэг удаа үнэт цаасны данс нээлгэн, мөнгөн гүйлгээ хийх дансаа баталгаажуулснаар орон зай харгалзалгүйгээр өөрийн харилцдаг банкаасаа ногдол ашгаа бэлэн мөнгөөр авах, цаашлаад энэ дансаараа дамжуулан арилжаанд оролцох, эргээд хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах боломж бүрдсэн.



СЗХ–ноос 2015 онд баталсан “Хадгаламжийн бичгийг бүртгэх, нийтэд санал болгон арилжих тухай журам”–ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмаар Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг боловч бусад орны томоохон биржүүд дээр хувьцаа нь арилжаалагддаг компаниуд хадгаламжийн бичиг гаргах замаар дотоодын хөрөнгө оруулагчдаар бааз сууриа тэлэх, нэмэлт эх үүсвэр татах боломжийг зохицуулсан ба журмыг илүү тодорхой болгож бодит нөхцөл байдалтай уялдуулсан.

Мөн СЗХ–ноос 2018 онд баталсан “Гадаад улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд Монгол Улсад үнэт цаас гаргах, Монгол Улсын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй хуулийн этгээд гадаад улсад гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”–д бирж хооронд хувьцаа хөрвөх нөхцөл буюу Монголын хөрөнгийн бирж дээр давхар бүртгэлтэй компанийн хувьцаа эзэмшиж байгаа иргэд хувьцаагаа гадаадын хөрөнгийн бирж рүү хөрвүүлэхэд “ҮЦТХТ” ХХК–аар дамжуулан хийх чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулан баталсан. Үүний хүрээнд “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн”–ийн Канад Улсын Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт хувьцааг Монгол Улсад давхар бүртгээд байна.

■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Мэргэжлийн хөрөнгө оруулагч нарт чиглэсэн биржийн бус зах зээлийн нарийвчилсан эрх зүйн зохицуулалтыг бий болгох, олон улсын жишигт нийцсэн биржийн бус зах зээлийг хөгжүүлэх үндэс суурийг тавих зорилгоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг боловсруулж СЗХ-ны 2020 оны 995 дугаар тогтоолоор батлав.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа нээгдсэнээр компаниудын хувьд хаалттай өрийн хэрэгслийг арилжаалах эрх зүйн орчин бүрдэж, үнэт цаас гаргахад цаг хугацаа, зардал хэмнэхээс гадна хөрөнгө оруулагчийн зүгээс хаалттай өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээл үүсэх, үнэт цаасны хөрвөх чадвар сайжрах, мэдээллийн ил тод байдал хангагдах зэрэг чухал ач холбогдолтой. Мөн нийтэд санал болгон гаргах үнэт цаасны шаардлага, шалгуурыг хангахад хүндрэлтэй байгаа жижиг, дунд үйлдвэрлэгч нарт биржийн бус зах зээлээс санхүүжилт босгох таатай нөхцөл бүрдэнэ.

СЗХ-ны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ыг шинэчлэн боловсрууллаа. Уг төсөлд үнэт цаас гаргагч, зах зээлд оролцогчдод хүндрэл учруулж буй зохицуулалтыг арилгах, нийтэд санал болгон анх удаа болон нэмж хувьцаа гаргахтай холбоотой харилцааг олон улсын жишигт нийцүүлэх, анхдагч зах зээлийн арилжааг андеррайтерийн компаниар дамжуулан зохион байгуулах, үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлсэн.

Үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж,





мэргэжлийн оролцогч, зуучлагчдыг чадавхжуулж, үнэт цаасны зах зээлд шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны номинал дансны зохицуулалтын орчинг бүрдүүлээ.

Ингэснээр үнэт цаасны зах зээлд оролцогч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээ болон үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийг түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн өмчлөх эрхийн шууд хэлбэрийн тогтолцоонд шилжүүлж, үйлчилгээ үзүүлэгчид тавигдах санхүү, хүний нөөц, программ хангамж, удирдлага, зохион байгуулалтын шаардлагыг чанаржуулж, үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлсэн шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.



■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Даатгалын зах зээл: Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай, Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүдийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж, хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн яамтай хамтран боловсруулж батлуулсан.



"Даатгалын багц дүрэм"-ийн холбогдох журам, зааврыг шинэчилж, нэмэлт, өөрчлөлт оруулав:

Даатгалын зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг илүү ёс зүйтэй, шударга өрсөлдөөнтэй болгох замаар даатгуулагч олон нийтийн даатгалын салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх зорилго бүхий "Даатгалын зах зээлийн ёс зүйн журам"-ыг шинэчлэн боловсруулж СЗХ-ны 2020 оны 114 дүгээр тогтоолоор баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн.

Даатгалын тухай, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид болон УИХ болон ЗГ-аас баталсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээнүүдэд нийцүүлэн Олон улсын хянан шалгагчдын холбооноос боловсруулсан даатгалын тулгуур зарчмууд, гадаад улс орнуудын зохицуулалтын орчин, сайн туршлага, салбарын

үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг судалж, даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн зохистой засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцоо бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах, үйлчлүүлэгч, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын үйл ажиллагаанд дэвшилтэд технологийг ашиглах замаар даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж хүртээмжийг нэмэгдүүлэх, бизнесийг ёс зүйтэй явуулах зорилгоор "Даатгалын багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт" болон "Тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт"-ыг шинэчлэн боловсруулж, СЗХ-ны 2020 оны 959 дүгээр тогтоолоор баталлаа.


■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



ББСБ-ын салбар: Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Энэхүү хуулийн төсөлд тусгай зөвшөөрлийн тоог бууруулах, салбарын оролцогчдыг чадавхжуулах, олон талт санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэх боломжийг нэмэгдүүлж, мэргэшлийн институт болох, хөрөнгийн зах зээлийг дэмжих, технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний зохицуулалтыг бий болгож, хүүг бууруулах, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зохицуулалтыг тусгасан.



СЗХ-ны 2020 оны 495 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталснаар, гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудыг төрийн цахим төлбөрийн системд холбох зохицуулалтыг бий болгов. Мөн төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системийг үнэ төлбөргүйгээр ашиглан харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг явуулж, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, и-баримт олгох, Санхүүгийн мэдээллийн албанд харилцагчийн мэдээллийг үнэн зөв хүргүүлэх, хянах боломж бүрдсэн.



Зээлийн батлан даалтын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор СЗХ-ны 2020 оны 352 дугаар тогтоолоор “Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам”-д өөрчлөлт оруулж батлуулсан. Ингэснээр иргэд, ЖДҮ эрхлэгчдэд хүргэх батлан даалтын үйлчилгээний хүртээмж нэмэгдэх боломж бүрдсэн.



СЗХ-ны 2020 оны 998 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилан, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан. Үүний хүрээнд ангиллын нэршлийг олон улсын стандартад нийцүүлж, хугацаа хэтэрсэн өдрөөс хойш зээлдэгч 30 хүртэл хоногт багтаан эргэн төлөлт хийгдсэн нөхцөлд хэвийн ангилалд бүртгэх, ангилал буурсан активын ангиллыг дээшлүүлэх зэрэг зээлдэгчийн эрх ашгийг хамгаалсан, чанаргүй активт бүртгэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлсэн.

■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХЗХ–ны салбар: ХЗХ–ны зах зээлийн өрсөлдөөн болон хүртээмжийг дэмжих, бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, зохицуулалтыг боловсронгуй болгох хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго бүхий Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

УИХ–ын Эдийн засгийн байнгын хорооны 2020 оны 10 дугаар сарын 27–ны өдрийн 02 дугаар тогтоолоор байгуулсан Хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.

СЗХ–ны 2018 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”–д 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 1022 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан.

УБЕГ–тай хамтран улсын бүртгэлд бүртгүүлсэн боловч тусгай зөвшөөрөл авахаар СЗХ–нд хандаагүй, хандсан боловч нөхцөл шаардлага хангаагүйн улмаас тусгай зөвшөөрөл олгоогүй, эсхүл тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 285 ХЗХ–г улсын бүртгэлээс хасав.

■ БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



УИХ-аас 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулан зохицуулах, хяналт тавих үүргийг СЗХ хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбар:

СЗХ-ны 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”, 121 дүгээр тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг, 181 дүгээр тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг тус тус баталсан.



Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчдийн салбар: СЗХ-ны 2020 оны 150 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”, 151 дүгээр тогтоолоор зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг, 182 дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг тус тус баталсан.

Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төвтэй хамтран тусгай зөвшөөрөл бүхий үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэн явуулж буй зах худалдааны төвүүдэд QR код байршуулах ажлыг хэрэгжүүлж эхлүүлсэн. Дэвшилтэт технологи бүхий үйлчилгээ нэвтрэх орчныг бүрдүүлэх нь хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалж, иргэдэд мэргэжлийн үйлчилгээ авах нөхцөлийг бий болгох юм.

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдээс 2020 оны 2 дугаар улирлаас эхлэн тайлан мэдээг ФинА системээр хүлээн авч, зайны хяналтыг хэрэгжүүлэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд зайны хяналт, шалгалтыг хялбаршуулахтай холбогдон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжааг нэгдсэн системээр бүртгэдэг болсон.

БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3. Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд



Салбарын холбоодтой /ХААГБТЭБНМБНХ, ММНБИ, ММУИ, МХХ, МБХ, МДХ, МДЗХ, ҮМҮЧАЭҮХ/ сургалт зохион байгуулах болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээг үзэглэв.

Мэргэжлийн холбоодтой хамтран 28 удаагийн сургалтыг цахимаар зохион байгуулж нийт 980 иргэнд гэрчилгээ олгов.



Даатгалын ач холбогдол, Мөнгө угаахтай тэмцэх, Комплайнс, компанийн засаглал, Санхүүгийн луйвар ба понзи, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа сэдвээр ГАРЫН АВЛАГА боловсруулж хэвлүүлэн олон нийтэд түгээв.

СЗХ-ноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Иргэдэд зориулсан “Таны санхүүгийн боловсролд” мэдээллийн дэлгэцийг байршуулан ажиллуулав. Уг дэлгэцээр СЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, зохицуулалтын салбарын талаар богино хэмжээний анимейшн, подкаст, нэвтрүүлэг зэргийг хүргэлээ.



СЗХ нь Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран долоо хоног тутмын “Санхүүгийн зах зээлийн цаг” радио нэвтрүүлгийг эхлүүлээд байна. Энэхүү нэвтрүүлгээр СЗХ-ноос явуулж буй бодлого, зохицуулалтын үйл ажиллагаа болон олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хүрээнд иргэдэд санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгох, олон нийтийг санхүүгийн эрсдэлээс хамгаалахад чиглэсэн анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвлөмж, мэдэгдэл, мэдээллийг Монголын үндэсний радиогийн 100.9 сувгаар дамжуулан олон нийтэд хүргэх зорилготой юм.

БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төвтэй хамтран “Хувьцаа 1072”, “Санхүүгийн хэрэглэгчийн хамгаалал”, “Мөнгө угаахтай тэмцэх”, “Даатгал” сэдвээр ТЕЛЕ ХИЧЭЭЛ бэлдэж Стар ТВ-ээр түгээсэн.



СЗХ-ноос олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд Даатгалын ерөнхий ангилал, даатгалын нөхөн төлбөр, олон нийтэд үнэт цаас гаргах, ББСБ-ын үндсэн үйл ажиллагаа, Зээл, Компанийн бонд, Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, Хөрөнгийн зах зээл, Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалах, Хөрөнгө оруулалтын сан, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэрэг сэдвээр подкастыг бэлтгэн түгээж байна.

Мөн СЗХ-ны цахим хуудсанд “Таны санхүүгийн боловсролд” болон www.ikon.mn цахим хуудсанд “Санхүүгийн боловсрол” булан тус тус үүсгэн иргэдэд зориулсан санхүүгийн мэдээллийг хүргэж байна.



"КОВИД-19"-ИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО

Үнэт цаасны зах зээл: УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Коронавируст халдварын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээ"-ний 6.5-д заасны дагуу "НОСК" хаалттай ХК-аас хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах ажиллагаанд бэлтгэж, "НОСК нэг" ХХК-д түрээсийн орлогоор баталгаажсан буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгох, 15 жил хүртэл хугацаатай орон сууцны түрээсээр баталгаажсан 34.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 343,580 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн бол СЗХ-ны 12 дугаар сарын хурлаар "НОСК хоёр" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрлийг олгоод байна. Үүний хүрээнд коронавирусын цар тахлын голомтод ажиллаж байгаа 1200 гаруй төрийн албан хаагчдыг түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцанд хамруулах ажлыг зохион байгуулж, Монголбанкнаас санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, СЗХ-ноос хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл олгох, үнэт цаасыг бүртгэх, хөрөнгө итгэмжлэн удирдагчид тусгай зөвшөөрөл олгох, оролцогч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, зохицуулалт тавьж ажиллах юм.


Зах зээлийн арилжаанд оролцоход гарах хэлцлийн зардлыг бууруулах, арилжаа хийгдэх шат дамжлагыг багасгах чиглэлээр дэд бүтцийн байгууллагуудад чиглэл өгөх, холбогдох дүрэм, журамд орсон өөрчлөлтүүдийг батламжлах ажлууд хийж байна.

болгосон. Мөн клирингийн үйлчилгээний шимтгэл нийтлэг 0.24 хувь байсныг үнэт цаасны төрөл тус бүрд тохирсон хувь хэмжээг тодорхой буюу хувьцааг цэвэршүүлсэн үнийн дүнгээс (ЦҮД) 0.24 хувь, Засгийн газрын бонд ЦҮД-ээс 0.00375 хувь, компанийн бонд ЦҮД-ээс 0.0075 хувь болгон бууруулсан.

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Зээлийн хүүг бууруулах стратеги"-ийг хэрэгжүүлэх дэд арга хэмжээний 1.4.1-д заасны дагуу "Уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрийн салбарын зээлдэгчид бага хүүтэй зээл олгох нөхцөлийг банкнаас олгосон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах, уг үнэт цаасыг барьцаалан Төв банкны репо санхүүжилтийг 1-2 жилийн хугацаатай, бодлогын хүүтэй ойролцоо дүнтэй санхүүжилтийн эх үүсвэр олгох зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхэд СЗХ хамтран ажилласан. СЗХ болон Монголбанкаас 937 дугаар тогтоолоор "МУЦСК" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөл, "Үнэт цаас санхүүжилтийн корпорац" ХХК-д СЗХ-ны 2020 оны 882 дугаар тогтоолоор хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус олгосон. Дээр дурдсан зээлийн хүүг бууруулах хүрээнд хийгдэх ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр СЗХ болон Монголбанк хамтран ажиллаж, бодлогоор дэмжсэнээр санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг нэмэгдүүлэх, зээлийн хүү буурах зэрэг чухал ач холбогдолтой.

Үүний үр дүнд анхдагч зах зээлийн арилжааны төлбөрийн шимтгэлийг 50 хувиар бууруулж 0.12 хувь —

СЗХ-ноос хувьцаат компаниудыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим мэдээллийн технологийг ашиглан, зайнаас зохион байгуулах зөвлөмжийг хүргүүлсэн ба цахимаар хурал зохион байгуулсан байдлын судалгааг гаргав. Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахимаар зохион байгуулах зохицуулалтын журмын төслийг боловсруулан олон нийтээс санал авсан. Журам батлагдсанаар хувьцаат компанийн уг цахим хурлаар жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх зөрчигдөхгүй байх, оролцох боломжоор тэгш хангагдах, санал хураалт үнэн зөвөөр явагдах, хурлын үйл ажиллагаа ил тод байх нөхцөл бүрдэх юм. —



"КОВИД-19"-ИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО

Даатгалын зах зээл: "Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт"-д даатгагч, даатгалын зуучлагч нь даатгалын гэрээг цахимаар болон аливаа дэвшилтэд технологи ашиглан байгуулахад тавигдах шаардлагууд болон даатгагчийн ТУЗ-өөс баталж, хэрэгжүүлэх технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг хөгжүүлэх бодлого, журамтай байх шаардлагуудыг тусгаснаар бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн үед даатгалын компаниуд утсаар болон фейсбүүк мессенжер буюу чатбот ашиглан, эдгээрээс гадна 5 даатгалын компани гар утасны аппликейшн ашиглан зөвлөгөө өгөх, даатгалын гэрээ байгуулах, даатгалын тохиолдлын талаар мэдээлэл болон нөхөн төлбөрийн баримт материалыг хүлээн авч ажиллалаа.

ЗГ-аас ипотекийн зээлийн хүүг 6 сараар царцаасан арга хэмжээг авсантай уялдуулан даатгалын компаниуд Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг хойшлуулав.

Даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын байгууллагад аудитын үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулах эрх олгох 4 удаагийн сургалт, шалгалтыг онлайн хэлбэрээр зохион байгуулав.

/Коронавирусийн халдвар 2020 оны 3 дугаар сард Монгол Улсад анх бүртгэгдэх үед/

"Нэйшнлайф даатгал" ХХК нийгмийн хариуцлагынхаа хүрээнд халдварын өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж буй улсын эмнэлгийн ажилтнууд, онцгой байдлын албан хаагчид болон төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг үнэ төлбөргүйгээр даатгах "Ковид-19 Амь нас, хөдөлмөрийн чадвар алдалтын даатгал"-ын н

бүтээгдэхүүнийг гаргасан.

"Мандал даатгал" ХК-аас боловсруулсан "Ковид хүртээмжтэй даатгал"-ын бүтээгдэхүүнийг түргэн шуурхай бүртгэж ажиллалаа. Уг даатгалын бүтээгдэхүүн нь коронавирусаар халдварлаж тусгаарлагдсаны улмаас алдах орлогоо үнэлгээний хязгаарын хүрээнд нөхөн төлбөр хэлбэрээр авах боломжтой бүтээгдэхүүн юм. Тус компани өөрийн харилцагч 82,000 даатгуулагчдаа үнэ төлбөргүй даатгасан ба дотоодод уг халдвар илэрснээс хойш буюу 11 дүгээр сарын 10-ны өдрөөс тус бүтээгдэхүүний борлуулалтыг фэйсбүүкийн чатботоор дамжуулан борлуулж, 1,529 гэрээ байгуулжээ.

/Коронавирусийн цар тахлын тохиолдол 2020 оны 11 дүгээр сард дотооддоо тархаж Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед/

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн үед иргэд, даатгуулагчдад зориулсан коронавирсийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломжтой "Ковид-19" эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг "Нэйшнлайф даатгал" ХХК-аас боловсруулж ирүүлснийг СЗХ цахимаар хянаж бүртгэлээ. Ингэснээр иргэд, даатгуулагчид уг даатгалын бүтээгдэхүүнийг цахимаар худалдан авах, нөхөн төлбөрөө шуурхай шийдвэрлүүлж тус вирусийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах боломж бүрдсэн. "Ард даатгал" ХК-ийн Коронавирусийн цар тахлын улмаас үүсэх эрсдэлээс хамгаалах хариуцлагын даатгалын бүтээгдэхүүнийг шуурхай хянаж бүртгэв.



"КОВИД-19"-ИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО

ББСБ-ын салбар:

СЗХ-ны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан "Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам"-д 2020 оны 148 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх хугацааг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэрийг гаргасан.

ББСБ-ын салбарын чанаргүй активын хэмжээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Банк бус санхүүгийн байгууллагын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 122/58

дугаар тушаал, СЗХ-ны 2020 оны 854 дүгээр тогтоолоор тус бүр нэмэлт оруулж, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд мөрдөхөөр шийдвэрлэсэн. Үүний үр дүнд 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 193.3 мянган зээлдэгчээс 257.4 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлснээр 265 ББСБ үйл ажиллагаа нь тасалдаж хүндрэл үүссэн 189.5 мянган зээлдэгчийн 226.2 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулж, зээлийн хугацааг дунджаар 108 хоногоор сунгаж, зээлийн ангилал буурахаас урьдчилан сэргийлсэн байна.



ЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 183 дугаар тогтоолын дагуу зээлийн үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудад тогтоосон хугацаанд зээлийн гэрээний хугацааг 2 болон түүнээс дээш удаа сунгасан тохиолдолд ангилал бууруулахгүй байх, иргэд аж ахуйн нэгжид олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг хойшлуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги, ногдуулж, хүүг нэгтгэж тооцох зэргээр зээлдэгчид нэмэлт дарамт үүсгэхгүйгээр, төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахыг үүрэг болгож мэдэгдсэн.



"КОВИД-19"-ИЙН НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО

ХЗХ-ны салбар: Монгол Улс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс эдийн засгийн идэвхжил саарч, иргэд, аж ахуйн нэгжийн хэвийн үйл ажиллагаа алдагдаж, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх эрсдэл үүссэний улмаас санхүүгийн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, тогтвортой байдлыг хадгалах зорилгоор СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 122/58 дугаар тушаалаар “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д нэмэлт оруулж, өөрчлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Түр журмын хугацааг Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгахаар СЗХ-ны 2020 оны 854 дүгээр тогтоолоор шийдвэрлэж, улмаар 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл сунгахаар 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 1023 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн. Үүний үр дүнд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 129 ХЗХ-ны 6,868 зээлдэгчдээс 27 тэрбум төгрөгийн зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт ирүүлснээс 4,756 зээлдэгчийн 17.9 тэрбум төгрөгийн зээлийн гэрээг шийдвэрлэн гэрээнд өөрчлөлт оруулж, үндсэн төлбөр болон хүүг төлөх хугацааг сунгаж 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр болгон хойшлуулах шийдвэр гаргасан.

Онцгой нөхцөл байдлын үед ХЗХ-дын гишүүдийг нэг дор олноор цуглуулахгүйгээр цахим хэрэгсэл ашиглан хуралдуулах, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцоог хангах зэргээр өөрийн хоршооны онцлогт тохируулан боломжтой хэлбэрээр хурлыг зохион байгуулах чиглэлийг СЗХ-ноос өгсний дагуу ХЗХ-д бүх гишүүдийн ээлжит хурлыг цахимаар хийж, шаардлагатай шийдвэрүүдийг гаргасан байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн ч тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа хүсэлтийг Зөвшөөрлийн цахим системээр дамжуулан хүлээн авч хянаж байна. Үүний үр дүнд



2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тусгай зөвшөөрөл авах 11, тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах 35, нэмэлт зөвшөөрөл авах 3, салбар байгуулах зөвшөөрөл авах 2, сонгуульт болон гүйцэтгэх захирлын өөрчлөлт бүртгүүлэх 9, хаяг байршлын өөрчлөлт бүртгүүлэх 2 ХЗХ-ны хүсэлтийг тус тус цахимаар хүлээн авч хянасан.

Коронавирусийн цар тахалтай холбогдуулан “Хадгаламж, зээлийн хоршооны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг түр хугацаанд хэрэгжүүлж ажиллахтай холбогдуулан ХЗХ-дод тайлангийн хариугаар мэдэгдэж, зарим нэр бүхий ХЗХ-дын цахим хаягаар зөвлөгөө, тайлбарыг тухай бүр өгч ажилласан.

БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үнэт цаасны зах зээл: 2020 онд дараах бүртгэл, зөвшөөрлийг олгосон. Үүнд:

- Үнэт цаасны дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 1;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 1;
- Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэх тухай 5;
- Хамтын хөрөнгө оруулалтын сангийн тусгай зөвшөөрөл 1;
- Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх 1;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх хуулийн этгээдээр бүртгэх 2;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээ хийх хуулийн этгээдээр бүртгэх 2;
- Хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох 4;
- ХААБ-ийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох 2;
- Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох 3;
- Номинал дансаар дамжуулан харилцагчдад брокерийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл олгох 5;
- Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл 2 зэрэг болно.

Зураг 5. Үнэт цаасны зах зээлийн тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл



Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийг 57 хүнд олгосон.



Даатгалын болон мэргэжлийн оролцогч компанийн салбар нээх 46 тусгай зөвшөөрлийг олгосон.

Даатгалын актуарчийн эрх болон бүртгэлийг 2 хуулийн этгээдэд олгосон.

Даатгалын зах зээл: 2020 онд дараах бүртгэл, зөвшөөрлийг олгосон. Үүнд:

- Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл 6;
- Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогч компанийн салбар нээх тусгай зөвшөөрөл 47;
- Даатгалын бүтээгдэхүүний бүртгэл 52;
- Төлөөлөгчийн газар нээх бүртгэл 2;
- Даатгалын актуарчийн эрх болон бүртгэл 2;
- Даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл 57;
- Даатгалын байгууллагад аудит хийх эрх 1;
- Аудитор 1;
- Даатгалын компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийн зөвшөөрөл 5 зэрэг болно.

БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зураг 6. ББСБ-ын салбарын тусгай зөвшөөрлийн мэдээлэл



ББСБ-ын салбар: ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 14 компанид шинээр олгож, 8 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, 34 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 1 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн сэргээж, 7 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн хүчингүй болгож, 19 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, нэр бүхий 2 ББСБ-ын үйл ажиллагааг нэгтгэн 1 банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон.

ХЗХ-ны салбар: 14 ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгож, 2 ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж, 49 ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, 26 ХЗХ-ны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон бол 7 ХЗХ-нд салбар нээх зөвшөөрөл олгон 7 ХЗХ-ны хаяг, байршлын өөрчлөлт, 31 ХЗХ-ны сонгууль болон эрх бүхий бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгэжээ.

Хүснэгт 3. ББСБ-уудын зөвшөөрөл, бүртгэлийн мэдээлэл

№	Зөвшөөрөл, эрхийн нэр	Тоо
1	Оноосон нэр өөрчлөх	7
2	Нэмэлт тусгай зөвшөөрөл олгох	21
3	Салбарын зөвшөөрөл олгох	29
4	Салбар хаах	2
5	Төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгох	2
6	Хаяг, байршлыг өөрчлөх	60
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	165
8	Эрх бүхий албан тушаалтныг томилох	92



БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын салбар

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 167 компанид шинээр олгосон.




Хүснэгт 4. Үл хөдлөх хөрөнгө зуучлалын салбарын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн тоо

№	Зөвшөөрөл, бүртгэлийн нэр	Тоо	
		Иргэн	Хуулийн этгээд
1	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл		2
2	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн брокерийн бүртгэл	188	
3	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн агентын бүртгэл	1,171	
4	Хаяг, байршлын өөрчлөлт		4

Үнэт металл, үнэт чулуу тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын чиглэлээр арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 30 хуулийн этгээд, 399 иргэнд олгосон.

Хүснэгт 5. Үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбарын тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн тоо

№	Зөвшөөрлийн нэр	Тоо	
		Иргэн	Хуулийн этгээд
1	Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	231	15
2	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	111	3
3	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл	57	12
4	Салбарын зөвшөөрөл		1



■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ЗАЙНААС ТАВИХ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД:

Зохицуулалтын байгууллагуудаас ирүүлсэн сар, улирлын санхүүгийн тайлан тэнцэл болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангуудыг хүлээн авч хянан, зөрчил, дутагдлыг арилгах талаар тайлангийн хариугаар хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажиллалаа. Давхардсан тоогоор сар болон улирлын нийт 8,742 санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан, мэдээнд зайны хяналтыг хийж гүйцэтгэлээ.

Үнэт цаасны зах зээл: 78 үнэт цаасны компанид 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хариугаар хугацаатай үүрэг даалгавар, 20 андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй компани IPO болон хаалттай хүрээнд бонд гаргахтай холбоотой анхааруулга, 58 ҮЦК-уудад 2020 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайлантай холбоотойгоор, 2 дугаар улиралд 53 ҮЦК-д, 3 дугаар улиралд зохистой харьцаа хангаагүй 11 ҮЦК, тайлан ирүүлээгүй 10 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 4 ХАА-н брокерт мэдэгдэл хүргүүлсэн. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг нэр бүхий 80 ҮЦК-д хүргүүлсэн.

Даатгалын зах зээл: Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын журмыг хэрэгжүүлэх чиглэлээр 16 даатгагчдын эрсдэлийн үнэлгээг улирал бүр гаргаж, тайлангийн хариугаар мэдэгдэж ажилласан.

ББСБ-ын салбар: “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ыг нийт 538 ББСБ-д цахим байдлаар хүргүүлэн хяналт тавин ажиллав.

ХЗХ-дын салбар: Тусгай зөвшөөрөл бүхий ХЗХ-доос бүх гишүүдийн хурлын материалыг ирүүлвэл зохих 221 ХЗХ-ны 191 нь ирүүлж, хурлын ирц болон хурлыг Хадгаламж, зээлийн хоршооны хуулийн дагуу явагдсан эсэхийг хянав.

Нийт тусгай зөвшөөрөл бүхий ХЗХ-доос санхүүгийн тайланд аудит хийлгэх үүрэг бүхий 191 ХЗХ-ноос 182 нь аудитын тайлан, дүгнэлтээ ирүүлснийг хянав.

Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр нэр бүхий 120 ХЗХ-нд эрсдэлийн үнэлгээг сүүлийн 12 улирал буюу 3 жилийн байдлаар хийж зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд эрсдэлийн үнэлгээ хийсэн.

Нийт давхардсан тоогоор ХЗХ-дод 353 тайлангийн хариу, 27 мэдэгдэл хүргүүлээ.

Зураг 7. Зайны хяналт, шалгалтын мэдээлэл /давхардсан тоогоор/



Үнэт цаасны арилжааны хяналтын тогтолцоог сайжруулах, үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл болон хурлын материалыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянаж, нэгдсэн дүгнэлт гаргах чиглэлийн хүрээнд:

Нийт 174 ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хянаж, хурлаа хуралдуулсан 134 ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг хянан хариу хүргүүлсэн. Нэр бүхий 63 ХК хувьцаа эзэмшигчдийн хурлаа хуралдуулаагүйг СЗХ-

ны цахим хуудсаар олон нийтэд мэдээлсэн. 93 ХК ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг СЗХ-нд ирүүлснээс 2020 онд 35 хувьцаат компани 132.7 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 127,653 хувьцаа эзэмшигчдэд тус тус олгохоор шийдвэрлэсэн. Мөн “Эрдэнэс таван толгой” ХК 2020.12.24-ний өдрийн байдлаар 2,008,854 хувьцаа эзэмшигчдэд 143.8 тэрбум төгрөгийн ногдол ашгийг тараасан.

■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХҮРЭЭНД:

Үнэт цаасны зах зээл: 1072 хувьцааны ногдол ашиг тараахтай холбоотой иргэдээс ирүүлсэн санал хүсэлттэй холбогдуулан 6 ҮЦК-д газар дээрх үзлэг, 8 ҮЦК-ийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийж, тайлангаар үүрэг даалгавар өгсөн.

Нэр бүхий 8 ХК-д газар дээр хийгдсэн шалгалтаар хугацаатай албан бичиг УБАШ хүргүүлж, биелэлтийг тооцсон. 244 ХК-д үүрэг даалгавар өгч орон нутаг дахь СЗХ-ны төлөөлөгчтэй хамтран ажиллаж уг албан бичгийг компаниуд руу хүргүүлж, 67 ХК-д хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа зарлан хуралдуулаагүйтэй холбоотой анхааруулга, мэдэгдэл хүргүүлсэн.

Даатгалын зах зээл: Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 9 банкны даатгалын зуучлалын үйл ажиллагаанд ипотекийн даатгалын үйл ажиллагааны журамд нийцэж байгаа эсэх, зуучилсан болон ипотекийн даатгалын гэрээг хууль, тогтоомжид нийцүүлж байгуулсан эсэх, зуучилсан даатгалын гэрээ, хураамжийн орлогын тооцоог даатгагчтай нийлсэн байдал, СЗХ-ноос өгсөн үүрэг даалгаврын биелэлт зэргийг газар дээр нь шалгаж, илэрсэн алдаа дутагдлыг арилгуулах чиглэлээр газар дээрх хэсэгчилсэн шалгалт хийж, шалгалтын тайлан, УБАШ-аар үүрэг даалгавар, заавар, зөвлөгөө өгч ажилласан.


Даатгалын байгууллагуудад Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулж хяналт тавьж ажилласан ба тус хуулийг зөрчсөн байдал газар дээрх шалгалтаар илрээгүй.

ББСБ-ын салбар: Тайлант онд эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хүрээнд СЗХ-ны даргын тушаалаар нийт 59 ББСБ-ын үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийгдсэнээс хэсэгчилсэн шалгалт 58, бүрэн хэмжээний шалгалт 1 болно.

СЗХ-ны 2020 оны 495 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны үйл ажиллагааг зохицуулах, түүнд хяналт тавих журам”-ыг баталсан бөгөөд энэхүү журмын хүрээнд 2020 оны 9 дүгээр сард СЗХ-ны даргын 317 дугаар тушаалаар Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Төмөрчний гудамж, Найман шарга төвд гадаад валютын арилжаа эрхэлдэг нэр бүхий 37 ББСБ-д газар дээрх хэсэгчилсэн шалгалт хийсэн бөгөөд энэхүү шалгалтын хүрээнд тусгай зөвшөөрөлгүй валютын арилжаа эрхэлж байсан нэр бүхий 4 иргэнд нийт 16.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 1 хуулийн этгээдэд Зөрчлийн хуулийн дагуу зөрчлийн хэрэг нээн прокурорт шилжүүлэн, 33 ББСБ-д “Гадаад валютын арилжааны үйл ажиллагааны зохицуулалт, хяналтын журам”-ын хэрэгжилтийг ханган ажиллах талаар мэдэгдэл хүргүүлэв.

ХЗХ-ны салбар: СЗХ-ны даргын баталсан удирдамжийн дагуу 16 ХЗХ-нд газар дээрх шалгалт хийсэн. Нэр бүхий 13 ХЗХ-нд УБАШ-аар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Зураг 8. Газар дээрх хяналт шалгалтын мэдээлэл, салбарын оролцогчдоор



■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

УБАШ болон захиргааны хариуцлага ногдуулалтын биелэлтийг хангуулах талаар хяналт тавьж ажиллах хүрээнд 2020 онд 4 чиглэлээс нийт 72 УБАШ хүргүүлснээс үнэт цаасны хяналтын чиглэлээр 8, ББСБ-ын хяналтын чиглэлээр 38, ХЗХ-ны хяналтын чиглэлээр 13, даатгалын хяналтын чиглэлээр 13 УБАШ-ыг тус тус хүргүүлэн, шаардлагыг хангуулан ажиллаж байна.

Үйл ажиллагаа нь доголдсон, холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй зохицуулалтын байгууллагуудын 132 асуудлыг СЗХ-ны хуралдаанаар оруулж тусгай зөвшөөрлийг

түдгэлзүүлсэн 42, тусгай зөвшөөрлийг сэргээсэн 16, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон 70, ҮЦК-ийн харилцагчийг шилжүүлсэн 3, компанийн хэлбэр өөрчилсөн 1 асуудлыг тус тус хэлэлцэн шийдвэрлэлээ.

Тайлант онд хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангаагүй нийт 51 ББСБ-ын асуудлыг СЗХ-ны хуралдаанаар хэлэлцэн эдгээрээс 28 ББСБ-ын тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж, 17 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 6 ББСБ-ын тусгай зөвшөөрлийг сэргээсэн.

Зураг 9. Албан шаардлага, салбараар



Улсын тэмдэгтийн хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлс, торгууль шийтгэврийн төлөлтөд хяналт тавих ажлын хүрээнд 2020 онд нийт 2,451.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна.

Зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 495 ББСБ-ын 403 нь, 247 ХЗХ-ны 123 нь Зээлийн мэдээллийн сантай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн "Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах,

эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай" 32 дугаар тогтоолын 3.2-д заасны дагуу СЗХ-ны 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 480 дугаар тогтоолоор ХАА-н брокероос СЗХ-нд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг ХААБ-ээр арилжаалагдсан угаасан болон самнасан ноолуурын худалдах, худалдан авах гэрээний нийт үнийн дүнгийн 0.04 хувиас доошгүй байсныг 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн 6 сарын турш чөлөөлөв.

■ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Захиргааны, Иргэний, Зөрчлийн хэрэгт СЗХ–ны болон улсын байцаагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр тухай бүр шүүх хуралдаануудад биечлэн оролцож, нэхэмжлэл гардан авах, хариу тайлбар гаргах, холбогдох нотлох баримтыг гарган хүргүүлэх, хүсэлт гаргах, давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах зэрэг хэлбэрээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатанд оролцон ажиллаж байна.

СЗХ нь 2020 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны 14 хэрэг, шинээр 4 нэхэмжлэл шүүхэд гаргаж, 9 нэхэмжлэл хүлээн авч, нийт 27 шүүхийн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцлоо. Үүнээс 20 хэрэг нь хянан шийдвэрлэгдэж дууссан бөгөөд үлдсэн 7 нь хянан шийдвэрлэгдэх шатандаа байна. Эрх зүйн ангиллын хүрээнд Захиргааны байгууллага, албан тушаалтан тэдгээрийн шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой нийт хэргийн 78.6 хувь буюу 22–ийг Захиргааны хэрэг, 21.4 хувь буюу 6–г Иргэний хэрэг эзэлж байна.

Дээрх хэргүүдийн шийдвэр, магадлал, тогтоолын дагуу нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээдүүд нийт 180.0 сая төгрөгийн торгууль, нөхөн төлбөрийн мөнгөн дүнг СЗХ–ны дансанд төвлөрүүлэхээр болсон бөгөөд тайлант онд 80.6 сая төгрөгийн биелэлтийг хангууллаа.

2020 оны нийт 28 хэргээс 20 нь бүрэн хянан шийдвэрлэгдэж дууссан бөгөөд үүний 12 буюу 60 хувь нь нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн (СЗХ–ны талд шийдвэрлэсэн), 4 буюу 20 хувь нь нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн (СЗХ–ны эсрэг талд шийдвэрлэсэн), 4 буюу 20 хувь нь нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдсэнийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

НИЙТ ХЭРЭГ

28



ХЯНАН
ШИЙДВЭРЛЭГДСЭН

21



ХЯНАН
ШИЙДВЭРЛЭГДЭЖ
БУЙ

7



ИРГЭНИЙ
ХЭРЭГ

6

▲ 21.4%



ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

22

▲ 78.6%



ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хүрээнд: 2020 онд СЗХ-нд ирүүлсэн нийт 1,452 өргөдөл, гомдол, хүсэлтээс 779 нь утсаар хүлээн авсан дуудлага, 195 нь цахимаар, 478 нь бичгээр байсан ба 1415 нь хуулийн хугацаанд шийдвэрлэж, 37 өргөдөл, гомдол хянагдах шатандаа явагдаж байна.

2020 онд ЗГ-аас баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим

арга хэмжээний тухай” 2020 оны 183 дугаар тогтоолын 8 дахь заалтад ББСБ, ХЗХ-ноос иргэд, аж ахуйн нэгжүүдэд олгосон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийн хугацааг зээлдэгчийн хүсэлтийг харгалзан нэмэгдүүлсэн хүү, торгууль, алданги тооцохгүйгээр зээлдэгчид ямар нэгэн дарамт үүсгэхгүй байхаар төлбөрийн чадварт нь нийцүүлэн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой өргөдөл, гомдлын тоо өмнөх оноос 4 дахин нэмэгдсэн.

Зураг 10. Өргөдөл, гомдол, тэдгээрийн шийдвэрлэлтийн мэдээ



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА




ФАТФ-аас Монгол Улсыг 2019 оны 10 дугаар сард Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орны жагсаалт буюу "Саарал жагсаалт"-д оруулснаар Европын холбоо "Өндөр эрсдэлтэй улс орон"-ны жагсаалтад Монгол Улсыг нэмсэн. Харин 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр ФАТФ-ын нэгдсэн хуралдаанаар стратегийн дутагдалтай улс орны жагсаалтаас хассан тухай зарласан тул мөн оны 12 дугаар сарын 09-ний өдөр Европын холбооны "Хар жагсаалт"-аас гаргасан.

Үндэсний эрсдэлийн үнэлгээ

2020 оны 4 дүгээр сарын 27-нд Сангийн сайдын 90 дүгээр тушаалаар Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж тайлагнах ажлын хэсгийг байгуулсан. Энэ ажлын хүрээнд Дэлхийн банкны аргачлалаар нийт 10 модуль буюу салбар, чиглэлийн хүрээнд үнэлгээ хийснээс 6 модулийг СЗХ 82 гишүүний бүрэлдэхүүнтэй хариуцан ажиллаж байна. 2020 оны Үндэсний эрсдэлийн үнэлгээг Дэлхийн банкны аргачлалаар авч хэрэгжүүлж байгаагаас гадна мэргэжлийн холбоод, зохицуулалттай салбаруудын төлөөллийг ажлын хэсэгт хамруулж, холбогдох статистик мэдээг олон төрлийн эх үүсвэрээс цуглуулж, баталгаажуулж ажиллаж байгаагаараа онцлог юм.

СЗХ өөрийн зохицуулалттай салбаруудын үнэлгээг Модуль 4, 5, 6А, 6Б, 7 /үнэт металл, үнэт чулуу эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага/ болон 9-ийн хүрээнд хийж, тайланг боловсруулахдаа модуль тус бүрийн ажлын хэсэг, СЗХ-ны ажлын хэсгээр нийт 21 хэлэлцүүлгийг зохион байгуулж, тайланг дэлгэрэнгүй болон хураангуй хэлбэрээр, тоон мэдээллийг хавсралт болгон тухай бүр илгээж, СЗХ хариуцсан ажлаа бүрэн гүйцэтгэсэн.

Зураг 11 МУТСТ чиглэлээр гүйцэтгэсэн газар дээрх хяналт, шалгалт



МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалт зохион байгуулах

2020 онд СЗХ-ноос МУТСТ чиглэлээрх сургалтад 3,026 иргэнийг хамрууллаа. Үүнээс 1,500 гаруй этгээдэд цахимаар сургалт зохион байгуулав.

МУТСТ чиглэлээр нийт 54 сургагч багшийг бэлтгэв. Мөн салбаруудын мэргэжлийн холбоодтай сургалт зохион байгуулах гэрээг байгуулж, Банк санхүүгийн академитай сургалт зохион байгуулах чиглэлээр хамтран ажилласан.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарын авлагыг шинэчлэн боловсруулж, олон нийтэд хүргэв.

СЗХ-ны цахим хуудасны Мөнгө угаахтай тэмцэх цэсийг шинэчилж, МУТСТ холбоотой хууль тогтоомж, сургалтын материал, цаг үеийн мэдээ мэдээлэл, эрсдэлийн үнэлгээний тайлан, тэдгээрийн үр дүн, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх заавар зөвлөмж, гарын авлага зэргийг байршуулав.

Мөн МУТСТ цэснээс холбогдох бүхий л мэдээ мэдээллийг монгол, англи хувилбараар бэлтгэж Хамтын ажиллагааны зөвлөлтэй хамтарч www.amlcft.mn нэгдсэн сайтад байршуулж, олон нийтийн хүртээл болгов.

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр СЗХ, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газраас 2020 онд хамтран ажиллах төлөвлөгөө”-ний дагуу СЗХ-ноос дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. 2020 оны 8 дугаар сард Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын Гуравдугаар явцын тайланг баталж, ФАТФ-ын Зөвлөмж 14-ийг 2 шатаар ахиулж “бүрэн биелүүлсэн” гэж дүгнэв.

2020 оны 8 дугаар сард Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын Гуравдугаар явцын тайланг баталж, Зөвлөмж 28-ыг 1 шатаар ахиулж “ихэнхийг биелүүлсэн” гэж дүгнэв. 2020 оны 8 дугаар сард Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс Монгол Улсын Гуравдугаар явцын тайланг баталж, Зөвлөмж 28-ыг 1 шатаар ахиулж “ихэнхийг биелүүлсэн” гэж дүгнэв.



ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

СЗХ Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны Олон талт харилцан ойлголцлын санамж бичиг, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын 'Өргөтгөсөн' олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдэхээр бэлдэж байна. Ийнхүү нэгдсэнээр хил дамнасан санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр харилцан мэдээлэл солилцох олон улсын тогтолцоонд хамрагдах, даатгалын зах зээлийг хөгжүүлэх Холбооны 26 зарчмыг хэрэгжүүлэхэд өндөр хөгжилтэй зах зээлүүдийн техникийн туслалцаа авах боломж нээгдэх бол Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагын 'Өргөтгөсөн' олон талт хамтын ажиллагааны санамж бичигт нэгдсэнээр бусад улсуудтай солилцох мэдээллийн ангилал дээшлэх, ялангуяа зах зээлийг урвуулан ашиглахыг тогтоох, мөн зогсоох чиглэлээр мэдээлэл солилцоход харилцан туслалцах, түүнчлэн мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх зорилтын хүрээнд илүү нарийн нууцлалтай (classified) мэдээлэл солилцох тогтолцоонд нэгдэх чухал ач холбогдолтой.



Олон улсын санхүүгийн түншлэлийн төвийн богино болон урт хугацааны сургалт



Азийн орнуудад хүртээмжтэй даатгалын зах зээлийг хөгжүүлэхэд зохицуулалтын байгууллагын оролцоо хөтөлбөр /RPF1 III/



Захирлуудын зөвлөлийн гишүүн; "Зүүн Европ, Төв Азийн Бүсийн Санаачилга"-ын гишүүн /Зохицуулалттай этгээдүүдэд ногоон санхүүжилт нэвтрүүлэх төсөл/



Төсөв, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл



Санхүүгийн хянан шалгагчдын түншлэлийн хөтөлбөр



Бичил санхүүгийн байгууллагыг чадавхжуулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл; Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга зам, аргачлал, хяналт төсөл



Хүртээмжтэй даатгалын харилцан туршлага солилцох сүлжээний гишүүн; Бүс нутгийн Удирдах зөвлөлийн дарга



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн чадавхыг бэхжүүлэх төсөл /2-р шат/



Үнэт цаасны төлбөр, тооцооны Төлбөрийн эсрэг нийлүүлэлт (DvP) зарчим, дараа төлбөрт тооцооны T+2 горимыг нэвтрүүлэх төсөл; Монгол Улсын ББСБ-уудын эрх зүйн орчинг дэмжих төсөл



Олон улсын валютын сангийн Сингапур улс дахь бүс нутгийн сургалтын институцийн чадавхыг бэхжүүлэх богино хугацааны сургалт



БНЭУ-ын Үнэт цаас, биржийн зохицуулах хороо болон Даатгалын зохицуулалт, хөгжлийн газар Харилцан ойлголцлын санамж бичиг

ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

СЗХ нь санхүүгийн зах зээлийн чадавхыг сайжруулах чиглэлээр олон улсын банк, донор болон олон улсын хамтын нийгэмлэгийн байгууллагуудтай техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрүүдийг хамтран үр ашигтай хэрэгжүүлж ажиллалаа.



Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооноос байгуулсан даатгалын компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл, зах зээлийн чиг хандлага, цахим эрсдэл болон гуравдагч этгээдээр дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, түүнээс үүсэх эрсдэл зэргийг судалж, тухайн эрсдэлүүд нь даатгалын компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх, түүнийг хэрхэн бууруулах боломжийн талаар судлах зорилго бүхий “Даатгалын үйл ажиллагааны уян хатан байдлыг хангах” ажлын хэсэгт ажиллалаа.

Олон улсын даатгалын зохицуулагчдын холбооны гишүүн орнуудын коронавирусийн цар тахлын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон түүний үр дагаврын талаарх Монгол Улсын мэдээллийг хүргүүлсэн ба бусад улс орнуудын мэдээллийг солилцсон.

СЗХ-ны дарга Д.Баярсайхан, Олон улсын санхүүжилтийн корпорациас Монгол Улсад суугаа суурин төлөөлөгч Руфат Алимарданов нар 2020 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг цахим хэлбэрээр үзэглэсэн.



СЗХ ногоон санхүүжилтийг бодлогоор дэмжих, ногоон эдийн засгийг санхүүжүүлэх боломжийг нэмэгдүүлэх хүрээнд 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдөр СЗХ, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгтэй “Зохицуулалттай этгээдүүдэд ногоон санхүүжилт нэвтрүүлэх төсөл”-ийн гэрээг байгуулсан. Төслийн хүрээнд ББСБ-уудын ногоон санхүүжилтийн талаар мэдлэг, ойлголтын түвшинг үнэлэх, судлах, судалгаанаас гарсан үр дүнд үндэслэн ногоон бүтээгдэхүүнийг танилцуулах, зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр ББСБ-уудад сургалт зохион байгуулах юм. Сургалтын өмнө ББСБ-уудаас ногоон санхүүжилтийн мэдлэг, ойлголтыг үнэлэх судалгааг авсан бөгөөд нийт 263 ББСБ хамрагдсан.



■ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ

СЗХ нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэсэн урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог. Тухайлбал судалгааны үр дүн болон санал, зөвлөмжүүд дээр үндэслэн дараах баримт бичгүүдийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- СЗХ-ны мэдээллийн нэгдсэн сангийн журам;
- Сэндбокс зохицуулалтын орчны журам;
- Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр;
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөө .
- СЗХ нь 2020 онд мэдээллийн нэгдсэн санг өргөжүүлж, олон нийтэд банкнаас бусад санхүүгийн зах зээлийн статистикийн бюллетень

Коронавирусийн цар тахал тархсантай холбоотой гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг хангаж ажиллав.

Салбарын тойм, сэтгүүл, тоон мэдээлэл, судалгааны ажлыг СЗХ-ны цахим хуудас (www.frc.mn), цахим шуудан (rsa@frc.mn) болон 51-261012 утсаар холбогдон авах боломжтой.



2019–2020 онд 32
төрлийн судалгаа хийсэн

СЗХ байгуулагдсаны 15
жилийн ойд зориулсан
"СУДАЛГАА ТОВХИМОЛ"

Улирал бүр:
САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН ТОЙМ

Сар бүр:
"ХҮРТЭЭМЖТЭЙ
САНХҮҮ" сэтгүүл

Сар бүр:
САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН САРЫН ТОЙМ

7 хоног бүр:
САНХҮҮГИЙН ЗАХ
ЗЭЭЛИЙН 7 ХОНОГИЙН
МЭДЭЭ

■ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, КОМПЛАЙНС

СЗХ–ны 2011 оны 367 дугаар тогтоолоор баталсан “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”–ыг шинэчлэн боловсруулж, 2020 оны 880 дугаар тогтоолоор баталсан. Уг журмаар хувьцаа эзэмшигчдийн санал хуваагдахгүй байх, жижиг хувьцаа эзэмшигчид нэгдэж ТУЗ–д өөрсдийн төлөөллийг сонгох зэрэг боломж бүрдсэн.



Компанийн засаглалын үнэлгээний загвар буюу нийт 70 асуулт бүхий зайны үнэлгээний асуулгыг боловсруулсан ба газар дээрх хяналт шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж нийт 4 зохицуулалттай этгээдийн засаглалд үнэлгээ хийж холбогдох дүгнэлт, санал, зөвлөмжийг шалгалтын тайланд тусгасан.



холбоо” ӨЗБ, “Монголын хувьцаат компаниудын холбоо” ТББ, “Компанийн засаглалын институт” ТББ–тай хамтран ажиллаж байна.

“Нээлтэй нийгэм форум” ТББ–тай хамтран “Хувьцаат компанийн комплайнс, мэдээллийн ил тод байдал” хэлэлцүүлгийг 2020 оны 9 дүгээр сарын 17–ны өдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт хувьцаат компаниуд, санхүүгийн бусад салбарын оролцогч байгууллагууд, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачид зэрэг 140 гаруй төлөөлөл оролцсон.

Компанийн засаглал, комплайнсын чиглэлээр дараах сургалтуудыг зохион байгуулсан. Үүнд:

“Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ–тай хамтран СЗХ–ны албан тушаалтнуудад зориулсан компанийн засаглалын ахисан түвшний сургалт;

Үл хөдлөх хөрөнгийн компанидд зориулсан “Компанийн засаглал, комплайнс” сэдвээр 2 удаагийн сургалт;

Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн арилжаа эрхлэгчдэд зориулсан “Комплайнс” сэдвээр 2 удаагийн сургалт;

Даатгалын хохирол үнэлэгчдэд зориулсан “Санхүүгийн хэрэглэгчийн эрх, комплайнс” сургалт;

Даатгалын зуучлагчдад зориулсан “Санхүүгийн хэрэглэгчийн эрх, комплайнс” сургалт;

“Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо” ТББ–аас зохион байгуулсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Комплайнс” сэдвээр сертификатжуулах сургалт.

Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрт:

- компанийн ёс зүйн дүрэм;
- цалин урамшууллын бодлого;
- залгамж халааны бодлого;
- дотоод аудитын бодлого;
- ногдол ашгийн бодлого;
- эрсдэлийн удирдлагын бодлого;
- дотоод хяналтын бодлого зэрэг компанийн ТУЗ–өөс баталж, дотооддоо мөрдөх шаардлагатай нийт бодлогын баримт бичиг, дүрмийн төслийн загварыг боловсруулж, СЗХ–ны цахим хуудсанд байршуулсан.

Компанийн засаглалыг сайжруулах хүрээнд “Компанийн засаглалын үндэсний зөвлөл” ТББ, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн


ХУВЬЦААТ КОМПАНИЙН КОМПЛАЙНС, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

2020 оны 9 сарын 17-ны өдөр

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

Тусгай зөвшөөрлийн цахим систем:

Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн үйл ажиллагааг бүрэн цахимжуулж “Зөвшөөрлийн цахим систем”-ийг бүрэн ашиглалтад орууллаа.



Төрийн болон зохицуулалтын байгууллага бусад аж ахуйн нэгжүүдтэй тоон гарын үсэгт суурилсан албан бичиг солилцооны үйл ажиллагааг нэвтрүүлснээр түүнд суурилсан гэрээг нэвтрүүлэх боломжтой боллоо.


СЗХ болон Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан ба энэ ажлын хүрээнд E-Mongolia-д мэдээлэл солилцох зорилгоор ХҮР, ДАН системүүдтэй физик холболт хийв.



Мөн СЗХ-ны дотоод үйл ажиллагааг цахимжуулахаар Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны нэгдсэн удирдлагын системд шилжихээр бэлтгэл ажил хангагдлаа.

■ ТӨСӨВ, САНХҮҮ

Зураг 12. Төсвийн гүйцэтгэл




2020 онд 4,567.5 сая төгрөгийн төсөвтэйгөөр үйл ажиллагаагаа явуулж, үүний 63 хувийг улсын төсвийн санхүүжилтийн, 37 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу зохицуулалт үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээр тус тус санхүүжүүлснээр СЗХ-ны үйл ажиллагааг жигд тогтмол тасралтгүй хэвийн явуулах санхүүгийн нөөцөөр хангаж ажилласан.

Тайлант онд зохицуулалт үйлчилгээний орлого 2.1 тэрбум төгрөг төвлөрснөөс 51.9 хувь буюу 1,069.0 сая төгрөгийг ББСБ-ын салбараас, 31.7 хувь буюу 652.0 сая төгрөгийг даатгалын салбараас, 15.2 хувь буюу 312.1 сая төгрөгийг үнэт цаасны салбараас, 1.3 хувь буюу 26.2 сая төгрөгийг ХЗХ-ны салбараас тус тус бүрдүүлжээ.

Улсын төсөвт тэмдэгтийн хураамжийн орлого 40.4 сая төгрөг, торгуулийн орлого 352.2 сая төгрөгийг тус тус төвлөрүүллээ.

Зураг 13. Нийт зардал /хувиар/



ОЛОЛТ, АМЖИЛТ

СТРАТЕГИЙН
ДУТАГДАЛТАЙ
УЛС ОРНЫ
ЖАГСААЛТААС
ГАРСАН

АНХНЫ ХАМТЫН
ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН САН
БАЙГУУЛАГДАВ

ББСБ-ЫН НИЙТ
ХАРИЛЦАГЧДЫН 88.4
ХУВЬ ТЕХНОЛОГИД
СУУРИЛСАН ЗЭЭЛИЙН
ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРТЭХ
БОЛОМЖТОЙ

НЭГДСЭН
УДИРДЛАГЫН
СИСТЕМД
ШИЛЖИХЭЭР
БЭЛТГЭЛ
ХАНГАГДАВ

ТООН ГАРЫН
ҮСЭГТ
СУУРИЛСАН
АЛБАН БИЧИГ
СОЛИЛЦОО

СЗХ-НЫ ҮЙЛ
АЖИЛЛАГАА
БҮРЭН
ЦАХИМЖИВ.

ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН
ЦАХИМ СИСТЕМД
ШИЛЖИВ

2020



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia